

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"
ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар
/дүгээр/ сарын 23-ны өдрийн 26/24
тоот тушаалын хавсралт...07



SOLOMON INVESTMENTS

БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ БОДЛОГО

Баримт бичгийн төрөл/ Type:

Бусад оролцогч талуудтай харилцах,
хамтран ажиллахад баримтлах бодлого

Хамрах хүрээ/ Area:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"
ХХК-ИЙН холбогдох ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй

Баримт бичгийн дугаар/Number:

..... м/ 26/38

Боловсруулсан/ Prepared by:

.....

Баталсан/ Approved by:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөл

Хуудасны тоо/ Page number:

5 хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

..... тусгай 1 удаа

Батлагдсан огноо/ Effective date:

2026 оны 03 дүгээр сарын 23

БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого (цаашид "Бодлого" гэх)-ын зорилго нь Компанийн засаглалын кодексын холбогдох зарчмыг хэрэгжүүлэх, Компанийн бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үндсэн зарчим, чиглэлийг тодорхойлох, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү бодлогод заасан "Бусад оролцогч талууд" гэж Компанийн ажилтан, харилцагч, хөрөнгө оруулагч, ханган нийлүүлэгч, төрийн байгууллага, улс төрийн нам болон Компанийн үйл ажиллагаанд нөлөө бүхий бусад этгээдийг ойлгоно.
- 1.3. Компани нь бусад оролцогч талуудтай харилцахдаа тэдгээрийн хэрэгцээ, шаардлага, ашиг сонирхлыг харгалзан үзэж, Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, Компанийн дотоод дүрэм, журам, бодлогыг мөрдөн ажиллана.
- 1.4. Энэхүү бодлогод тусгайлан зохицуулаагүй асуудлыг холбогдох хууль тогтоомж болон Компанийн бусад дүрэм, журам, бодлогын дагуу шийдвэрлэнэ.
- 1.5. Компани нь дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 1.5.1. Хууль дээдлэх;
 - 1.5.2. Ил тод байдал;
 - 1.5.3. Улс төрийн хараат бус байдал;
 - 1.5.4. Тэгш харилцаа;
 - 1.5.5. Авлигаас ангид байх;
 - 1.5.6. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 1.5.7. Компанийн нэр хүндийг хамгаалах.
- 1.6. Энэхүү бодлогод хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.6.1. "Компанийн ажилтан" гэж Компанитай хөдөлмөрийн гэрээ болон бусад холбогдох гэрээ байгуулан ажиллаж байгаа этгээдийг;
 - 1.6.2. "Төрийн байгууллага" гэж Улсын Их Хурал, хараа байгууллагууд, Ерөнхийлөгчийн харьяа байгууллагууд, Шүүх эрх мэдлийн байгууллагууд, Засгийн газар болон түүний харьяа яамд, тэдгээрийн хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын шадар сайд, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан байгууллагууд, аймаг, нийслэлийн бүх шатны Засаг даргын тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад төрийн байгууллагыг;
 - 1.6.3. "Ханган нийлүүлэгч" гэж Компанийн шаардлагыг хангасан, бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхээр сонгогдсон иргэн, хуулийн этгээдийг;
 - 1.6.4. "Харилцагч" гэж Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж байгаа болон ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг;
 - 1.6.5. "Улс төрийн нам" гэж Монгол Улсын Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу иргэд улс төрийн үзэл бодол, үнэт зүйл, нийтлэг ашиг сонирхолд үндэслэн сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, төрийн эрх мэдлийг хууль ёсны аргаар хэрэгжүүлэхэд оролцох зорилго бүхий байгууллагыг;

- 1.6.6. "Хариуцсан нэгж" гэж Компанийн дүрэм, бодлого, журамд заасны дагуу бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах чиг үүрэг бүхий газар, хэлтэс, нэгжийг.
- 1.7. Энэхүү бодлогод тодорхойлоогүй нэр томъёог Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон Компанийн бусад дотоод баримт бичигт заасан утгаар тайлбарлана.

ХОЁР. БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

- 2.1. Компани болон түүний ажилтан нь бусад оролцогч талуудтай тэгш, шударга харилцаж, аливаа хууль бус нөлөөлөлд автахгүйгээр бие даасан, хараат бус байдлаа хадгалан, Компанийн болон бусад оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр хүндийг эрхэмлэн ажиллана.
- 2.2. Компани нь бусад оролцогч талуудын үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, шашин шүтлэг, үзэл бодол болон бусад ялгаатай байдлаас үл хамааран тэгш харилцах зарчмыг баримтална.
- 2.3. Компани нь бусад оролцогч талуудын оруулж буй хувь нэмрийг үнэлж, харилцан ашигтай, тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэн ажиллана.
- 2.4. Компани нь бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, шаардлагатай эрсдэлийн үнэлгээ хийж, тухайн этгээдийн хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээг харгалзан үзнэ.
- 2.5. Компани нь бусад оролцогч талуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 2.5.1. Харилцагч (төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд);
 - 2.5.2. Компанийн ажилтан;
 - 2.5.3. Ханган нийлүүлэгч;
 - 2.5.4. Төрийн байгууллага.
- 2.6. Компани нь бусад оролцогч талуудтай харилцахдаа тухайн оролцогч талын Компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө болон сонирхлын түвшинг харгалзан үзнэ.

Харилцагч болон Компани хоорондын харилцаа

- 2.7. Компани нь харилцагчдыг холбогдох дотоод журамд заасны дагуу ангилж, тухайн харилцагчийг хариуцсан нэгжээр дамжуулан харилцаж, хамтран ажиллана.
- 2.8. Компани нь харилцагчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, найрсаг, шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх замаар урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 2.9. Компани болон түүний ажилтан нь харилцагчтай харилцахдаа холбогдох хууль тогтоомж, Компанийн дотоод дүрэм, журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллана.
- 2.10. Компани нь харилцагчидтай өөрийн албан ёсны цахим хуудас, цахим шуудан, утас, сошиал суваг болон бусад боломжит харилцааны хэрэгслээр дамжуулан харилцаж, мэдээлэл солилцоно.

Компани болон ажилтан хоорондын харилцаа

- 2.11. Компани нь ажилтнуудтайгаа харилцан хүндэтгэл, итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлж, ажил үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.12. Компани нь ажилтнуудтайгаа байгууллагын цахим шуудан, дотоод мэдээллийн систем, албан ёсны цахим хуудас болон бусад дотоод харилцааны сувгаар дамжуулан харилцана.
- 2.13. Компани нь ажилтнуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, санал хүсэлтээ уламжлах боломжийг бүрдүүлж, удирдлага болон ажилтнуудын харилцааг нээлттэй байлгах бодлого баримтална.

- 2.14. Компани нь ажилтнуудын санал санаачилгыг дэмжиж, тэдний нийтлэг эрх ашгийг хамгаалах хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.15. Компани нь ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг дэмжих, сургалт хөгжилтэй холбоотой дотоод журамтай байна.

Ханган нийлүүлэгч болон Компани хоорондын харилцаа

- 2.16. Компани нь ханган нийлүүлэгчтэй харилцахдаа хариуцсан нэгжээр дамжуулан харилцана.
- 2.17. Компани нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дотоод журамтай байх бөгөөд ханган нийлүүлэгчтэй харилцахдаа уг журмыг мөрдөн ажиллана.
- 2.18. Компани нь ханган нийлүүлэгчдэд шударга өрсөлдөөний тэгш боломж олгож, ил тод, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Төрийн байгууллагатай харилцах харилцаа

- 2.19. Компани болон түүний ажилтан нь төрийн байгууллагатай харилцахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажиллана.
- 2.20. Компани болон түүний ажилтан нь төрийн байгууллага, албан тушаалтантай харилцахдаа дараах зарчмыг баримталж ажиллана. Үүнд:
 - 2.20.1. Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд ил тод харилцах;
 - 2.20.2. Ажил хэрэгч байдлаар хамтарч ажиллах;
 - 2.20.3. Хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
 - 2.20.4. Ажил үүргээ гүйцэтгэхэд хууль тогтоомж, дүрэм журамд заасан албан шаардлагыг төрийн байгууллага, албан тушаалтанд тавих;
 - 2.20.5. Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад нэр хүндээ ашиглах, өөрөөр амлуулахгүй байх;
 - 2.20.6. Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдаас шан харамж авах, шан харамж өгөхийг шаардахгүй байх;
 - 2.20.7. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой давуу байдал үүсгэх, давуу эрх эдлүүлэх, эсхүл нийтийн давуу байдлыг үүсгэх, давуу эрх эдлүүлэхээр ажиллахгүй байх;
 - 2.20.8. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан өөрт эсхүл Компани болон албан тушаалынхаа нэрийн өмнөөс давуу байдал болох, өөрт эсхүл өөрийн хамаарал бүхий, холбогдох аливаа этгээдэд давуу байдал, давуу эрх эдлүүлэх, ингэх давуу байдал, давуу эрх эдлүүлэхийг бусдаас шаардахгүй байх.
 - 2.20.9. Компани нь улс төрийн хараат бус байдлыг баримтлах бөгөөд аливаа улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг байгууллагын нэрийн өмнөөс дэмжих, эсхүл эсэргүүцэх үйл ажиллагаанд оролцохгүй.
 - 2.20.10. Компанийн хөрөнгө, эд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, техник хэрэгсэл, хүний нөөцийг улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.
 - 2.20.11. Компанийн ажилтан нь өөрийн хувийн улс төрийн үзэл бодол, байр суурийг Компанийн албан ёсны байр суурь мэтээр илэрхийлэхгүй.
 - 2.20.12. Төрийн байгууллагын шийдвэрт нөлөөлөх зорилгоор аливаа төлбөр, хандив, бэлэг, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

ГУРАВ. БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

- 3.1. Компанийн газар, хэлтэс, нэгжийн ажилтан бүр өөрийн эрхэлсэн ажил, үүргийн хүрээнд харилцагч болон бусад оролцогч талуудын хэрэгцээ, шаардлага, хүлээлтэд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлнэ.
- 3.2. Компани нь бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, журам, бодлогыг мөрдөж ажиллана.

- 3.3. Компани нь бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ил тод, шударга, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, аливаа үйлчилгээ, мэдээллийг хүндрэл чирэгдэлгүй, шуурхай хүргэхийг эрмэлзэнэ.

Бусад оролцогч талуудыг мэдээллээр хангах

- 3.4. Компани нь өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр болон бусад холбогдох мэдээллийг бусад оролцогч талуудад үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ. Үүнд:
- 3.4.1. Шинээр нэвтрүүлсэн болон шинэчлэн сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг хариуцсан нэгж нь Компанийн цахим хуудас, цахим шуудан, сошиал суваг болон бусад боломжит хэрэгслээр дамжуулан хүргэнэ.
- 3.4.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцагч болон бусад оролцогч талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор сургалт, уулзалт, форум, өдөрлөг болон бусад арга хэмжээг зохион байгуулж болно.
- 3.4.3. Компани нь бусад оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо тогтоох зорилгоор санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж, холбогдох мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан шуурхай, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэнэ.
- 3.4.4. Төрийн байгууллага болон улс төрийн асуудалтай холбоотой аливаа мэдэгдэл, тайлбарыг зөвхөн эрх бүхий албан тушаалтан өгнө.
- 3.5. Компани нь бусад оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох журамд заасны дагуу шуурхай шийдвэрлэж, тэдгээрийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.
- 3.6. Компани нь жилийн үйл ажиллагааны тайландаа бусад оролцогч талуудтай хамтран ажилласан үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ, баримталсан бодлого, хүрсэн үр дүнгийн талаар товч мэдээлэл тусгана.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бүх шатны ажилтан оролцож, өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 4.2. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.
- 4.3. ТУЗ нь энэхүү бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, Компанийн засаглалын кодекс болон холбогдох хууль тогтоомжийн шаардлагын хэрэгжилтийг үнэлж ажиллана.
- 4.4. Энэхүү бодлогод тусгайлан зохицуулаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм болон бусад дотоод дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.